

Баянтал сумын цаг үеийн мэдээ / 05 дугаар сар/

2018.05.25

“ЛҮН”

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Сумын 152,154-р байрны орцны дарга, суманд үйл ажиллагаа явуулдаг ААНБ-тай сумын Засаг дарга хэлэлцүүлэг зохион байгуулж 7 хоног бүрийн баасан гарагт ААНБ-ууд ойр орчмын талбайг цэвэрлэх, 14 хоног тутамд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

ЗДТГ-ын болон 4-р сургууль, 4-р цэцэрлэг, Соёлын төв, ЭМТөв, Талын-Илч ОНҮӨГ-ын 2017 оны үйл ажиллагааны тайланг ном болгон хэвлэн иргэдэд тараасан. 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 2017 оны ЗДТГ-ын жилийн эцсийн тайлан болон 2018 оны 1-р улирлын тайланг 1,2-р багийн иргэд хөдөлмөрчиддээ танилцуулж санал бодлыг нь сонслоо.

2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудтай “Санамж бичиг”, “Хариуцлагын гэрээ”-г байгууллаа. Уг уулзалтаар ААНБ-ууд болон залуучуудын төлөөлөлтэй уулзан санал бодлыг нь сонсон тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцлээ.



2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

2018 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 4,890,0 гүйцэтгэл 1,422,9 мянган төгрөг төвлөрүүлсэн 71,36 хувьтай байна.

Орон нутгийн байгууллагын зарлагын төлөвлөгөө 105,264,0 мянган төгрөг, гүйцэтгэл 92,669,5 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин, унаа хоол, нэмэгдэл урамшуулалд 57,461,8 мянган төгрөг НДШ 6,232,3 мянган төгрөг зарцуулсан байна.

Улсын төсвийн байгууллагын зарлагын төлөвлөгөө 336,434,6 мянган төгрөг, гүйцэтгэл 273,384,9 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин, унаа хоол, нэмэгдэл урамшуулалд 129,998,9 мянган төгрөг НДШ 13,882,0 мянган төгрөг зарцуулсан ба цалин хөлс хугацаандаа олгогдсон.

Орон нутгийн төсвийн байгууллагын өглөг 522,7 мянган төгрөг, Орон нутгийн төсвийн байгууллагын авлага 2,686,8 тусгай зориулалтын байгууллагын өглөг 10,270,0 нийт өглөг 1,540,5 мянган төгрөг байна.

3. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготонотой тэмцэх тандалтын судалгааг 13155 га-д талбайд хийж энгийн механик аргаар тэмцэхээр Инвест Ко-оп Монгол төсөлд хандаж хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлүүлэхээр санал тавьсан.

Үлийн цагаан оготонотой тэмцэхэд малчдын оролцоог хангах үүднээс хэлэлцүүлэг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

2018 оны 05 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд “Малчдаа сонсоё” Малчдын чуулга уулзалтыг зохион байгуулж нийт 90 малчин, мал бүхий өрх хамрагдсан. Уулзалтанд аймгийн ХХААГазар, ХХҮГазар, Нийгмийн даатгалын хэлтэс, Статистикийн хэлтэс мэдээлэл хийсэн. Чуулга уулзалтаар нийтээр мод тарих уриалга гаргаж малчид болон төсвийн 6 байгууллагын албан хаагчид, ААНБ-ын 100 гаруй иргэд нийт 250 ширхэг мод суулгацыг цэцэрлэгт хүрээлэнд тарьлаа. /чацаргана 50 ш, шар хуайс 50 ш, улиас 50 ш, хайлаас 100 ш/. Мод услагааны ажлыг төсвийн 6 байгууллагад цагийн хуваарь гарган эзэнжүүлсэн.



Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил хийгдэж 68780 толгой мал хамрагдаж вакцинжуулалтын ажил 76.4 %-тай явагдаж байна. Бруцеллёз өвчний тандалтын судалгаанд 8 өрхийн 110 ямаа, 45 үхрийг шинжилгээнд хамруулсан.

4. БАГИЙН МЭДЭЭЛЭЛ

2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 1-р багийн Багийн Иргэдийн нийтийн хурал боллоо. БИНХ-аар 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын тайлан, 2019 онд хэрэгжүүлэх ажлуудыг хурлаар хэлэлцэн эрэмбэллээ.

5. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас сумын шилдэг 5 гэр бүлийг шалгарууллаа. Үүнд: авьяаслаг гэр бүл Л.Гантөгс, бүтээлч гэр бүл Э.Хүрэлбаатар, өнөр гэр бүл Н.Суурь, оюунлаг гэр бүл П.Ганбаатар, спортлог гэр бүл Ц.Баясгалан нар шалгарлаа. Мөн гэр бүлийн хос дууны уралдаанд 5 гэр бүл оролцож, нийтийн цэнгээнт бүжиг болж үйл ажиллагаа өндөрлөлөө.



6. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Нийт үзлэг – 156

Урьдчилан сэргийлэх үзлэгш – 76

Амбулаторын үзлэг - 116

Алсын дуудлага – 10

Ойрын дуудлага – 18

5-р сарын байдлаар 11 жирэмсэн эх байгаагаас 1 жирэмсэн эхийг шинээр ханалтанд авч жирэмсэн эхчүүдийн биеийн байдал сайн үзлэг шинжилгээндээ хэвийн бүрэн хамрагдсан.

5сарын байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 12 эмнэлгээс гарсан 15 хүн байна.

5-р сард ямар нэгэн халдварт өвчин гараагүй.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгийн 61 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 44 хүүхдэд А витамин уулгасан.



7. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД

Аж ахуй, бичил бизнес эрхлэх хүсэлтэй “Цагаан айраг” хоршооноос 1 иргэн “Бизнесээ эхэл” сэдэвт 5 хоногийн аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдаж, гэрчилгээ олгосон.

2018.05.10 нд Нийгмийн салбарын байгууллагуудын “иргэдэд үйлчлэх” өдөрлөгөөр байнгын асаргаа шаардлагатай 3 иргэний гэрээр очиж музейн явууллын үйлчилгээ үзүүлсэн байна.

2018.05.15 нд Төслийн ажлын хэсгийн ирж санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар төслөө ирүүлсэн 3 иргэний гэрээр очиж төслийн бодит байдал, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнтэй нь танилцав.

. Мэдээг нэгтгэсэн:

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Ц.Булган

Хянасан:

ЗДТГ-ын дарга

В.Гантуяа

